

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 7 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 14 цаг 08 минутад эхэлж, 14 цаг 50 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 42 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Баянхонгор аймагт зохион байгуулсан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2014 оны 02 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 06 - ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Баянхонгор аймагт 2014 оны 02 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 46 иргэнээс 37 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 9 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 10 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын</p>

		<p>төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 5 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтаар баталсан нэр бүхий 15 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Баянхонгор аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Тахарын албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай</p>	<p>Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.8, 35 дугаар зүйлийн 35.1.3, 35.1.9, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 1.3-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 06 -ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. "Тахарын албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Тахарын албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын үнэлгээ, дүн гаргах заавар"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Тахарын албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход авах</p>

		<p>мэргэшлийн шалгалтын дүнгийн хуудас"-ны загварыг гуравдугаар хавсралтаар, "Тахарын албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэнийг нөөцөд бүртгэх жагсаалтын загвар"-ыг дөрөвдүгээр хавсралтаар, "Бүртгэлийн хуудасны загвар"-ыг тавдугаар хавсралтаар, "Тахарын албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалтын зохион байгуулалтын хяналтын хуудасны загвар"-ыг зургаадугаар хавсралтаар тус тус батлах</p> <p>2. Тахарын албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнийг сонгон шалгаруулахдаа энэхүү журам, зааврыг баримталж ажиллахыг Тахарын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	"Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д өөрчлөлт оруулах тухай	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 03/256 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх хэсгийг: "...Шүүхийн ерөнхий зөвлөлд Шүүхийн хүний нөөцийн газрын дарга,байна." гэж өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

